



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑᠑ оны ᠐᠑ сарын 14 өдөр

Дугаар А/361

Мандалговь

Тусгай зөвшөөрөл цуцлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гурвансайхан сумын нутаг "Билүүт" гэх газарт "Эрдэнэс трак" ХХК-ний ХҮ-48000007 (008/Ду) тоот талбай, "Хүрэн дэл" гэх газарт "Эм Би Консалтинг" ХХК-ний ХҮ-48000064 (016/Ду) тоот талбайд тусгай зөвшөөрөлгүйгээр удаа дараа ердийн ашигт малтмал болох хайлуур жонш олборлосон тул дээрх компаниудын тусгай зөвшөөрлийг цуцалсугай.

2. Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг цуцласан тухай мэдээллийг холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдэд мэдэгдэж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Гурвансайхан сумын Засаг дарга (Э.Адъяабаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111700